

МОНГОЛ ГАР БИЧМЭЛ АНАГААХ УХААНЫ ЭРТНИЙ СУДРААС СҮҮДЭР ӨВЧНИЙ ЭМИЙН ТУС ЭРДМИЙГ ТОДРУУЛАХ НЬ

Баярсайхан Сумъяа¹, Баттогтох Гэрэлмаа^{2*},
Дашжамц Шагдарсүрэн¹, Шараев Болд^{1,2}

¹Уламжлалт Анагаах Ухааны Тэнхим, Эм Зүйн Шинжлэх Ухааны Их Сургууль, Улаанбаатар хот, Монгол Улс

²Уламжлалт Анагаах Ухааны Сургууль, “Ач” Анагаах ухааны их сургууль, Улаанбаатар хот, Монгол Улс

*цахим хаяг: gerelmaa.b@ach.edu.mn

CLARIFYING THE DRUG ACTION FOR STROKE DISEASES FROM ANCIENT MONGOLIAN MEDICINAL MANUSCRIPTS

Sumiya Bayarsaikhan¹, Gerelmaa Battogtokh^{2*},
Shagdarsuren Dashjamts¹, Bold Sharav^{1,2}

¹Department of Traditional Medicine, Mongolian University of Pharmaceutical Sciences, Ulaanbaatar, Mongolia

²Department of Traditional Medicine, “Ach” Medical University, Ulaanbaatar, Mongolia

*email: gerelmaa.b@ach.edu.mn

Abstract

Introduction: A study sample of 78 manuscripts was selected from the 1,223 transferred from the 8th Khalkha Jebtsundamba's Library to the National Library of Mongolia. This sample consists of single, representative volumes from unique, multi-volume texts. Of the 78 manuscripts analyzed by Tungalag Batmunkh, eight (approx. 10%) are categorized as medical treatises. However, a systematic study conducted by Academician Bold Sharav identified a total of nine distinct volumes, thereby establishing a precise corpus of the works. One of these is the book “The book summarizes a number of conventional formulas from Tong Ren Tang Pharmaceutical Company”, which is one of the sources that has not yet been researched. This study was undertaken to determine the origin of the book, terminology, number, and category of medicines, and to clarify the drug action of some formulas. To determine the origin, terminology, number, and classification of the ancient medical book “The book summarizes a number of conventional formulas from Tong Ren Tang Pharmaceutical Company,” and to clarify the characteristics of the medicines included in the chapter “Drugs for **stroke** diseases.”

Methods: We employed methods such as the study of original texts and sources, and the checklist method.

Conclusion: The medications used in this book for stroke have the following benefits: thrombolytic, bone strengthening, tendon pain relief, support free breathing, relieve fever, antiplatelet, cure wind, regeneration bone marrow, improve testicle semen, and provide physical radiance, strength, and virility.

Keywords: ancient Mongolian, drug action, medicinal manuscript, stroke, Tong Ren Tang

Үндэслэл

Эх бичиг, сурвалж судлалын арга нь хүн төрөлхтний түүхэнд маш эртний уламжлалтай бөгөөд системтэй судалгааны арга хэлбэрээрээ МЭӨ III зууны үед эртний Грекийн Александрын номын сангийн эрдэмтдийн дунд анх үүссэн гэж үздэг. Орчин үе (XIX зуун)-д Германы түүхч Леопольд фон Ранке эх сурвалжийг шинжлэх ухааны үндэстэй шүүмжлэх (source criticism) аргыг боловсронгуй болгосноор сурвалж судлал бие даасан шинжлэх ухааны арга зүй болон төлөвшжээ¹.

Монгол Улсад 1921 онд Судар бичгийн хүрээлэн байгуулагдсанаар Монголын түүх, соёлын сурвалж бичгийг системтэйгээр цуглуулж, судлах ажил шинжлэх ухааны үндэстэйгээр эхэлсэн түүхтэй.

Ийнхүү сурвалж бичгийн болон эртний түүхийн археологийн олдворууд (чулуун зүү, ясан савх)-д үндэслэн хийсэн судалгааны дүнд Монголын уламжлалт анагаах ухаан нь нүүдэлчдийн соёлд тулгуурласан 5000 гаруй жилийн түүхтэй, эрүүл амьдрах ухааныг чухалчилдаг үнэт өв^{2,3,4} болохыг тодруулсан билээ.

VIII Богдын номын сангаас Монгол Улсын Үндэсний номын санд шилжүүлэн авч хадгалж байгаа монгол гар бичмэл 1223 номоос олон ботитой ном тус бүрээс нэг нэг хувийг төлөөлүүлэн авч, мөн цор ганц хувь номыг сонгох замаар нийт 78 гар бичмэл номыг судалгаанд авчээ. Энэ 78 гар бичмэл номын дотор анагаах ухаантай холбоотой 8 ном байна⁵ гэж Батмөнхийн Тунгалаг судлаач бүтээлдээ тэмдэглэсэн байна. Харин академич Ш.Болд судлан жагсааж үзээд 9 ном байгааг тодорхойлон гаргажээ. Эдгээрийн нэг нь “Тон рэн тан хэмээх эмийн пүүсийн боловсон эмийн хураангуй тоог тэмдэглэсэн дэвтэр” нэрт ном байгаа бөгөөд одоог хүртэл судалгааны эргэлтэд ороогүй байгаа сурвалж бичгийн нэг юм.

Тиймээс тус бүтээлийг сонгон авч гарал үүсэл, нэр томъёо, эмийн тоо, ангиллыг тогтоож, зарим эмүүдийн онцлогийг тодруулахаар энэхүү сэдвийг сонгон авлаа.

Зорилго: “Тон рэн тан хэмээх эмийн пүүсийн боловсон эмийн хураангуй тоог тэмдэглэсэн дэвтэр” нэрт анагаах ухааны эртний номын гарал үүсэл, нэр томъёо, эмийн тоо, ангиллыг тогтоож,

“Сүүдэр өвчний үүднээ эм нь” бүлэгт багтах эмүүдийн онцлогийг тодруулах

Зорилт:

1. Тус номын гарал үүслийг илрүүлж, гарчгийн нэр томъёог тайлбарлах
2. “Тон рэн тан хэмээх эмийн пүүсийн боловсон эмийн хураангуй тоог тэмдэглэсэн дэвтэр” номын эмийн тоо, ангиллыг тогтоох
3. Тэргүүн дэвтрийн “Сүүдэр өвчний үүднээ эм нь” бүлэгт багтах эмүүдийн хэрэглэх заалт дахь өвчний шинжийн тоо, онцлогийг тодруулах

Материал, арга зүй: “Тон рэн тан хэмээх эмийн пүүсийн боловсон эмийн хураангуй тоог тэмдэглэсэн дэвтэр”⁶ луун хээтэй шар өнгийн торгоор хавтсыг нь бүрж, дэвтэрлэсэн. Эрчилсэн шаргал өнгийн утас, тасарсныг цагаан утсаар сэлбэж холбон 4 цоолж, нуруулдсан. 23х27 см хэмжээтэй, хар бэхээр, үсэн бийрээр 12 мөрөөр бичсэн. Тэргүүн дэвтэр нь 318 нүүр, дэд дэвтэр нь 304 нүүр, бичгийн хэв тогтуун, монгол бичгээр бичигдсэн, эмийн манж нэршил бүхий гар бичмэл энэхүү бүтээлийг судлахдаа бид эх бичиг, сурвалж судлалын арга, магадлан жагсаах аргуудыг ашиглалаа.

Судалгааны үр дүн:

Х я т а д а а р 同仁堂 –Tóng rén táng (S a m e benevolence main room), монголоор “Өгөөмөр ээлт нэгэн зүйл гол танхим” гэж найруулан орчуулагдаж байна. Энэхүү пүүс Манж Чин гүрний эзэн хаан Энх-Амгалангийн найм дахь жил, 1669 онд үүсэн байгуулагдсан. Тиймээс энэ эмийн пүүс Манж Чин гүрний үеэс улбаатай, Манжийн эзэн хааны ордонд үйлчилж байсан урт түүхээрээ алдартай.

Энэ пүүс “Нийгэмд сайн сайхныг төлөвшүүлэх, хүн амыг эрүүлжүүлэх нандин дээд ёс суртахуун, буянтай үйлсийг хоёуланг нь төлөвшүүлэх” эрхэм зорилгыг баримтлан ажилладаг байжээ⁷. Тийм ч учраасTóng rén táng (Same benevolence main room) гэдгийг “Өгөөмөр ээлт нэгэн зүйл гол танхим” эсвэл “Ээл буянтай нэгэн зүйл гол танхим” гэж утгачилан орчуулагдана. Анх байгуулагдсан цагаас өнөөг хүртэл 356 жил болж байна. Одоо энэ пүүс Хятадын уламжлалт анагаах ухаан чиглэлээр мэргэшсэн, алдартай эмийн компани болсон.

Тон рэн тан эмийн пүүсийг үндэслэгч нь Жэжян мужийн Нинбо хотоос гаралтай, Мин гүрний Чонжен

(Chongzhen) хааны (1611-1644) үед Бээжинд нүүж ирсэн Лэ Сяньян юм. Өвөг дээдэс нь гурван үеэрээ эмч байсан. Тэрбээр хүүхэд ахуйдаа өвөг дээдсийнхээ эм найруулах явц, эмчилгээг байнга харж, сонсож байсан зүйлийнхээ нөлөөнд автаж, эмийн жор бэлтгэлийн талаар олон ном судалжээ. Улмаар эдгээр мэдээлэл, мэдлэг нь тэдний удмын бий болгосон эмийн туршлагат жортой сүлэлдэн нийлж эм үйлдвэрлэх гол гарын авлага нь болсон байна.

Лэ Сяньян эмийн худалдааг бусдад тусалж, амьжиргаагаа залгуулах хамгийн эцсийн зорилго хэмээн үзэж байв. Түүний хэлэх дуртай үг нь «Амьдрах, ертөнцөд туслах хамгийн чухал зүйл бол анагаах ухаан юм» гэдэг байжээ. Ингээд 1669 онд Тон рэн тан эмийн пүүсээ байгуулж эхэлсэн. Түүхэн баримтаас үзэхэд 1723 оноос Манж Чин гүрний Найралт төв (1723–1735) хаанаас хойш 188 жилийн турш Тон рэн тан хэмээх эмийн пүүс Манж Чин гүрнийг эм бэлдмэлээр хангаж байжээ.

Тиймээс:

“Эмийг ёсчлон найруулахад төвөгтэй байсан ч хөдөлмөрөө хэмнэхгүй

Эмийн түүхий эд өндөр үнэтэй байсан ч аль

нэгийг нь дутаах ёсгүй”

гэсэн зарчмыг баримталсаар иржээ.

Тухайн цагтаа VIII Богд Жавзандамба хутагт ийм л чухал эмийн пүүсийн жорын номыг “Тон рэн тан хэмээх эмийн пүүсийн боловсон эмийн хураангуй тоог тэмдэглэсэн дэвтэр” нэрээр хятад хэлнээс монгол хэлээр (эмийн манж нэршил бүхий) орчуулах зарлиг буулган өөрийн номын санд гар бичмэлээр хадгалж байжээ. Уг ном нь тэргүүн, дэд гэсэн 2 дэвтэртэй.

Луун хээтэй шар өнгийн торгоор хавтсыг нь дэвтэрлэсэн. Үүгээрээ эзэн хааны мэдлийн буюу нэн чухал ном гэдгийг илэрхийлж байна.

“Тон рэн тан хэмээх эмийн пүүсийн боловсон эмийн хураангуй тоог тэмдэглэсэн дэвтэр”-ийн тэргүүн дэвтэр нь: Нийслэл хотын төв Наран хаалганы гадна Да ши лан хутоны замын өмнө бүхий Тон рэн тан хэмээх эмийн пүүсийн боловсон эмийн хураангуй тоог тэмдэглэв гээд Сүүдэр өвчний үүднээ эм нь ... гээд эмийн жорын нэрийг жагсаан бичжээ. Эмийн нэрсийн дараа бидний хэлж заншсанаар эмийн тус эрдэм, уг дэвтэрт байгаагаар ач тусыг дараалуулан тодорхойлжээ.

Table 1. Number and category of medicines in the first book

Category No.	Category name	Quantities of medicines
I	Сүүдэр өвчний үүднээ эм нь	Medicines of the stroke 33
II	Халуун, хүйтэн харшилдсаны үүднээ эм нь	Medicines of contradicting disorders of hot and cold 27
III	Хижиг өвчний үүднээ эм нь	Medicines of contagious hot disorder 8
IV	Халуун хийгээд нойтон цэцгийн үүднээ эм нь	Medicines of smallpox of hot and wet 15
V	Гал мэт халууны үүднээ эм нь	Medicines of acute hot disorder 27
VI	Нөхөж нэмэрлэсний үүднээ эм нь	Medicines of invigorate 84
VII	Дэлүү ходоодны үүднээ эм нь	Medicines of the spleen and stomach 28
VIII	Зулгаслах хийгээд уруу суухын үүднээ эм нь	Medicines of endometritis and diarrhea 6
IX	Нүдний үүднээ эм нь	Medicines of the eyes disorders 19
X	Эхнэрүүдийн үүднээ эм нь	Medicines of gynecological disorders 44
XI	Муу цус хийгээд цэрээр ханиахын үүднээ эм нь	Medicines of hot cough with phlegm 30

XII	Уур амьсгал бөглөгдөхийн үүднээ эм нь	Medicines of asthma	35
XIII	Яр шархын үүднээ эм нь	Medicines of the lesions	48
XIV	Бяцхан хүүхдийн үүднээ эм нь	Medicines of pediatric disorders	54
XV	Хоолой, ам, шүдний үүднээ эм нь	Medicines of the throat, the mouth and the teeth	12
XVI	Нөхөж үлдсэний үүднээ эм нь	Other medicines	12

Хүснэгтэд үзүүлсэнчлэн энэ дэвтэрт 16 зүйлээр ангилан нийт 482 эмийн талаар өгүүлсэн байна.

“Сүүдэр өвчний үүднээ эм нь” бүлэгт буй өвчний шинжийг “...хүний мэдрэлгүй, үг өгүүлэл үл чадах, уруул хазайж, хамар, зовхи унжин, нүд зөрүү болж, хагас бие хөдлөхгүй, алхаж явахуйд маш бэрх, яс шөрмөс агтарч, эд бодь болоод амнаасаа цэр, шүлс цувируулан, гэнэт мангууран унаад, шүд нь зуурч, чөтгөр шүглэснийг үзсэн мэт, солио өгүүлэн, заримдаа дуулмуй. Заримдаа уйлмуй. Эсвээс мангуу, эсвээс тэнэг болж сэтгэл нь бараг бүрэг. Жич бас бяцхан хүүхэд гэнэт цочиж орхиод тахал тусах, жич жанчигдан унаад, хорт шарх олсон ...” гэх мэтээр өгүүлсэн байна. Уламжлалт анагаах ухааны онолын дагуу энэ өвчний хувиралтыг халуун зүрхний сүвд шургасан, жавар салхинд оногдсон, хий, хүйтэн нойтонд шадрыг үүсгэсэн, цул сав, арьс мах, үес гишүүнд хий шургаж үүсдэг болохыг тодорхойлон бичжээ. Энэ бүлгийн эмүүд нь цусан сүвийг нээгдүүлж, ясыг бэх болгож, шөрмөсийг талбируулан, уур амьсгалыг уужим болгоод, халууныг сэрүүтгэж, муу цусыг хайлуулан, хийг арилган чадах, чөмгийг дүүргээд дусал шимийг нэмэгдүүлж, тамир хүчийг сайжруулах тус эрдэмтэй байна.

Хэлцэмж

“Тон рэн тан хэмээх эмийн пүүсийн боловсон эмийн хураангуй тоог тэмдэглэсэн дэвтэр” хэмээх номд гарч буй “Сүүдэр” өвчний үед илрэх шинж тэмдгүүд нь “Анагаах ухааны дөрвөн үндэс”-ийн “Адын өвчнийг анагаах үес” дэх өвчний бэлэг чанаруудтай төстэй байна. Тухайлбал, “Анагаах ухааны дөрвөн үндэс”-ийн “Саа” өвчний ерөнхий бэлэг чанар нь “тал биеэ чирэх, нүдний судас илрэх, хэлгийрэх, ам хазайх бөгөөд уйлах ба инээх болой”⁸ хэмээжээ. Тэгвэл “Тон рэн тан хэмээх эмийн пүүсийн боловсон эмийн хураангуй тоог тэмдэглэсэн дэвтэр” хэмээх номд гарч буй “Сүүдэр”

өвчний үед илрэх шинжүүд нь орчин үеийн анагаах ухааны тархины цус харвалт, эпилепси (унаж татах), нүүрний саажилт өвчний шинж тэмдгүүдтэй таарч байна.

Дүгнэлт

Тус номд буй “Сүүдэр өвчний үүднээ эм нь” бүлгийн эмүүд нь цусан сүвийг нээгдүүлж, ясыг бэх болгож, шөрмөсийг талбируулан, уур амьсгалыг уужим болгоод, халууныг сэрүүтгэж, муу цусыг хайлуулан, хийг арилган чадах, чөмгийг дүүргээд дусал шимийг нэмэгдүүлж, тамир хүчийг сайжруулах тус эрдэмтэй байна.

Ном зүй

1. Michael Heller. Rethinking Historical Methods in Organization Studies: Organizational Source Criticism. European Group for Organizational Studies. Vol 44, Issue 6, 2023. <https://doi.org/10.1177/01708406231156978>
2. Болд Ш. Монголын уламжлалт анагаах ухааны түүх. УБ, 2011. х. 49.
3. Болд Ш., Жавхлан Б. Хүннүгээс XXI зууны Монгол Улс хүртэлх үеийн эмч, маарамба, гүүш бариач нарын цадиг, бүтээлийн ойллого. УБ, 2016, х. 261-269.
4. Болд Ш. Монголын уламжлалт анагаах ухаан: Гүн ухаан, онол, эрүүл биеийн судлал. УБ, 2012. х. 22.
5. Тунгалаг Б. Наймдугаар Богд Жавзандамба хутагтын номын сангийн гар бичмэл номын номзүйн судалгаа. Улаанбаатар, 2011, х. 31
6. Тон рэн тан хэмээх эмийн пүүсийн боловсон эмийн хураангуй тоог тэмдэглэсэн дэвтэр. Тэргүүн дэвтэр. х. 19-41.
7. John M.T. Balmer, Weifeng Chen. Corporate heritage tourism brand attractiveness and national identity. Journal of Product and Brand Management. 2016, 25, 3-4.
8. Ютог Ёндонгомбо. Анагаах ухааны дөрвөн

үндэс. Шин Вэй Лин, орч. ӨМӨЗО-ы Үндэсний
хэвлэлийн хороо, 1991. х. 1084-1106.

ᠰᠤᠳᠠᠯᠭ᠎ᠠ, ᠰᠢᠨᠵᠢᠯᠭᠡᠭᠡ